



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/12/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэт хот 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70359826 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Эрдэнэ Утас: 70355805 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Буян-Ундрах Утас: 70357955 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт	12
4.1 Залруулсан алдаа.....	12
4.2 Төлбөрийн акт	13
4.3 Зөвлөмж.....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 78

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН СУМ ДУНДЫН
ОЙН АНГИЙН ДАРГА
Д.ЭНХБАЗАР ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сум дундын ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сум дундын ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

ДАНС	Үзүүлэлт	Үлдэгдэл	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	15,436,829.84	18,184,829.84
35	БАРАА МАТЕРИАЛ	15,436,829.84	18,184,829.84
351	Түүхий эд материал	11,237,529.84	13,985,529.84
35110	Тусгай зориулалттай материал	11,237,529.84	13,985,529.84
354	Хангамжийн материал	4,199,300.00	4,199,300.00
35470	Бусад хангамжийн материал	4,199,300.00	4,199,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	839,400,294.93	887,932,155.19
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	839,400,294.93	887,932,155.19
392	Биет хөрөнгө	103,581,294.93	152,113,155.19
39201	Барилга, байгууламж, орон сууц	21,098,810.00	21,098,810.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,813,174.64	-4,219,761.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	87,483,000.00	152,456,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-55,850,298.19	-72,561,159.68
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	37,385,252.62	47,946,752.62
39206	Хуримтлагдсан элэгдэл	-26,920,012.02	-31,722,459.75
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,684,449.94	28,684,449.94
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,567,929.08	-12,374,631.68
39214	Бусад үндсэн хөрөнгө	31,789,440.00	31,789,440.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,708,243.70	-8,984,284.30
393	Биет бус хөрөнгө	735,819,000.00	735,819,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	735,819,000.00	735,819,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	854,837,124.77	906,116,985.03
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	854,837,124.77	906,116,985.03
51	Засгийн газрын хувь оролцоо	854,837,124.77	906,116,985.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	735,819,000.00	735,819,000.00
51101	Өмч: - төрийн	735,819,000.00	735,819,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	73,751,274.91	125,031,135.17
51210	Өмнөх үеийн үр дүн	73,751,274.91	73,753,237.76
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	51,277,897.41
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	45,266,849.86	45,266,849.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	854,837,124.77	906,116,985.03

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	145,889,100.00	215,856,170.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,042,500.00	81,093,270.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,042,500.00	81,093,270.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,042,500.00	81,093,270.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,291,000.00	2,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	751,500.00	79,093,270.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	143,846,600.00	134,762,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	39,150,000.00	37,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,150,000.00	37,500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	104,696,600.00	97,262,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	104,696,600.00	97,262,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	166,403,811.92	164,578,272.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	166,403,811.92	154,592,681.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	154,662,101.41	153,792,681.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	80,280,358.61	77,948,288.41
210101	Үндсэн цалин	53,829,104.06	59,143,847.09
210102	Нэмэгдэл	20,835,454.55	15,734,996.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,615,800.00	3,069,445.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,838,428.88	10,043,045.47
210201	Тэтгэврийн даатгал	7,126,230.33	7,347,788.31
210202	Тэтгэмжийн даатгал	727,205.57	701,082.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	581,762.66	560,866.22
210204	Ажилгүйдлийн даатгал	127,565.84	127,096.90
210205	Эрүүл мэндийн даатгал	1,275,664.48	1,306,211.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,415,204.00	2,493,270.52
210301	Гэрэл, цахилгаан	685,184.00	1,592,492.51
210302	Түлш, халаалт	498,268.00	496,993.79

Сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	231,752.00	403,784.22
2104	Хангамж, бараа материалын зардал	32,168,360.00	25,480,286.00
210401	Бичиг хэрэг	798,700.00	591,000.00
210402	Тээвэр, шатахуун	30,405,000.00	24,029,570.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	664,660.00	489,716.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.00	370,000.00
2105	Нормативт зардал	1,245,000.00	2,558,000.00
210502	Хоол, хүнс	00.00	1,190,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,245,000.00	1,368,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,611,000.00	4,666,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	630,000.00	00.00
210604	Урсгал засвар	2,981,000.00	4,666,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,924,000.00	1,846,200.00
210702	Дотоод албан томилолт	2,924,000.00	1,846,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,025,038.00	1,754,951.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,735,000.00	88,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	634,168.00	559,890.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	217,870.00	278,061.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	165,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,154,711.92	27,002,639.74
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,154,711.92	27,002,639.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,741,710.51	800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	800,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,941,710.51	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	9,985,591.45
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	9,985,591.45
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-20,514,711.92	51,277,897.41
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-20,514,711.92	51,277,897.41

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	735,819,000.00	45,266,849.86	73,900,929.15	854,986,779.01
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	735,819,000.00	45,266,849.86	73,900,929.15	854,986,779.01
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	20,365,057.68	20,365,057.68
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	735,819,000.00	45,266,849.86	73,751,274.91	854,837,124.77
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	735,819,000.00	45,266,849.86	73,751,274.91	854,837,124.77
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,962.85	1,962.85
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	735,819,000.00	45,266,849.86	73,753,237.76	854,839,087.62
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	51,277,897.41	51,277,897.41
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	735,819,000.00	45,266,849.86	125,031,135.17	906,116,985.03

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	145,137,600.00	136,762,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,291,000.00	2,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,291,000.00	2,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,291,000.00	2,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,291,000.00	2,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	143,846,600.00	134,762,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	39,150,000.00	37,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,150,000.00	37,500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	104,696,600.00	97,262,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	104,696,600.00	97,262,900.00

Сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	145,137,600.00	136,762,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	145,137,600.00	136,762,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	133,395,889.49	125,977,308.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	80,280,358.61	77,946,325.56
210101	Үндсэн цалин	53,829,104.06	59,141,884.24
210102	Нэмэгдэл	20,835,454.55	15,734,996.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,615,800.00	3,069,445.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,838,428.88	10,043,045.47
210201	Тэтгэврийн даатгал	7,126,230.33	7,347,788.31
210202	Тэтгэмжийн даатгал	727,205.57	701,082.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	581,762.66	560,866.22
210204	Ажилгүйдлийн даатгал	127,565.84	127,096.90
210205	Эрүүл мэндийн даатгал	1,275,664.48	1,306,211.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,415,204.00	2,493,270.52
210301	Гэрэл, цахилгаан	685,184.00	1,592,492.51
210302	Түлш, халаалт	498,268.00	496,993.79
210303	Цэвэр, бохир ус	231,752.00	403,784.22
2104	Хангамж, бараа материалын зардал	31,716,860.00	24,669,516.00
210401	Бичиг хэрэг	798,700.00	591,000.00
210402	Тээвэр, шатахуун	29,653,500.00	23,218,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	664,660.00	489,716.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	370,000.00
2105	Нормативт зардал	1,245,000.00	2,558,000.00
210502	Хоол, хүнс	00.00	1,190,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,245,000.00	1,368,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,791,000.00	4,666,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	810,000.00	00.00
210604	Урсгал засвар	2,981,000.00	4,666,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,924,000.00	1,846,200.00
210702	Дотоод албан томилолт	2,924,000.00	1,846,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,185,038.00	1,754,951.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	895,000.00	88,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	634,168.00	559,890.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	217,870.00	278,061.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	165,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,741,710.51	10,785,591.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,941,710.51	9,985,591.45
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,941,710.51	9,985,591.45
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	99,262,900.00	89,278,108.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	99,262,900.00	89,278,108.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	98,462,900.00	88,478,108.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	76,625,800.00	70,106,325.56
210101	Үндсэн цалин	52,115,400.00	51,301,884.24
210102	Нэмэгдэл	21,385,600.00	15,734,996.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,124,800.00	3,069,445.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,344,600.00	8,984,645.47
210201	Тэтгэврийн даатгал	7,279,500.00	6,289,388.31
210202	Тэтгэмжийн даатгал	766,300.00	701,082.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	613,000.00	560,866.22
210204	Ажилгүйдлийн даатгал	153,300.00	127,096.90
210205	Эрүүл мэндийн даатгал	1,532,500.00	1,306,211.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,089,200.00	1,493,270.52
210301	Гэрэл, цахилгаан	638,000.00	592,492.51
210302	Түлш, халаалт	1,014,000.00	496,993.79
210303	Цэвэр, бохир ус	437,200.00	403,784.22
2104	Хангамж, бараа материалын зардал	5,609,100.00	5,120,716.00
210401	Бичиг хэрэг	800,000.00	591,000.00

**Сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210402	Тээвэр, шатахуун	3,825,000.00	3,670,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	684,100.00	489,716.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.00	370,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	970,000.00	600,000.00
210604	Урсгал засвар	970,000.00	600,000.00
2107	Томилолт, зочны зардал	418,200.00	418,200.00
210702	Дотоод албан томилолт	418,200.00	418,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,406,000.00	1,754,951.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	450,000.00	88,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	640,000.00	559,890.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	280,000.00	278,061.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	165,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	800000.00	800000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	800,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	99,262,900.00	88,321,955.49
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	97,262,900.00	86,321,955.49
132001	Орон нутгийн төсвөөс	97,262,900.00	86,321,955.49
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,000,000.00	2,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	2,000,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сум дундын ойн ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Буян-Ундрах гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 11 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сум дундын ойн анги нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

1. Ойн санг ой хээрийн түймрээс хамгаалах.
2. Ойг хууль бус мод бэлтгэлээс хамгаалах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах.
3. Ойг хортон шавж, өвчнөөс хамгаалах, байнгын ажиглалт судалгаа хийж хортон шавж илэрсэн тохиолдолд яаралтай арга хэмжээ авах ажлыг зохион байгуулах.
4. Ойн төлөв байдлыг сайжруулах, ойг доройтлоос хамгаалах зорилгоор арчилгаа, цэвэрлэгээ хийж унасан модыг цэвэрлүүлэх арга хэмжээ авах.
5. Ойн санг гэрээгээр эзэмшиж буй ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагуудыг мэргэжил аргазүйн удирдлагаар хангаж ажиллах.
6. Аймаг, сумдын ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль,
- Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол.
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сум дундын ойн ангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 215,858.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,158.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,511.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Сум дундын ойн ангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 51,279.8 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	15,436.8	18,184.8	2,748.0
Үндсэн хөрөнгө	103,581.3	152,113.2	48,531.9
Нийт хөрөнгө	854,837.1	906,117.0	51,279.9
Засгийн газрын хувь оролцоо	854,837.1	906,117.0	51,279.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	854,837.1	906,117.0	51,279.9

Бараа материалын дансны үлдэгдэл 18,184.8 мянган төгрөг болж 2,700.0 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал болох хөрс бутлагч сийрүүлэгч, түймрийн үүргийн шүршигч авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 152,113.2 мянган төгрөг болж 48,531.9 мянган төгрөгөөр өссөн нь байгаль хамгаалах арга хэмжээ, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 75,534.5 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж үнэ төлбөргүйгээр авсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 155,099.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 157,099.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 55,800.0 мянган төгрөгөөр бууруулж, орон нутгийн төсвөөс 99,262.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 99,262.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгохоор төлөвлөжээ

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 86,322.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсөвт 9,900.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 88,478.1 мянган төгрөг буюу 89,9 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Байгаль орчин аялал жуулчлалын газраас талбай тусгаарлах ажлын санхүүжилт 10,000.0 мянган төгрөг, Эрдэнэт голын дагуу 1000 ширхэг улиас тарих ажлын санхүүжилт 13,000.0 мянган төгрөг, Цагаан чулуутын ам 600 ширхэг шинэс мод тарих ажлын санхүүжилт 12,000.0 мянган төгрөг, хортон шавжийн судалгааны ажил 2,000.0 мянган төгрөг, талбай тусгаарлалтын 500.0 мянган төгрөг тус тус нэмэлт санхүүжилтийн дансанд орсныг зориулалтын дагуу зарцуулж, 0.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тус газрын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллийг хугацаандаа оруулж, мэдээлсэн байна. Мөн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 124,700.0 мянган төгрөгийн 16 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 9,900.0 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээ бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд тогтоосон 1,409.7 мянган төгрөгийн дүнтэй 1 төлбөрийн актыг бүрэн барагдуулж, 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сум дундын ойн ангийн санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй ба дараагийн аудитаар нэмэлт санхүүжилтийн дансыг үзэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 420.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 420.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1 зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд залруулсан алдаа байхгүй.

4.2 Төлбөрийн акт

1. Орхон аймгийн Жаргалант сумын байгаль хамгаалагч нар сумынхаа нутаг дэвсгэрт буюу өглөө ажилд очих, орой буцах боломжтой газарт талбай тусгаарлах ажил хийсэн байтал томилолтын зардал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журмын 2.1-д "Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Урсгал зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Сум дундын ойн ангийн даргын тушаалаар 2021 оны 11 болон 12 дугаар саруудад шинээр 4 хүн ажилд авсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.2-д "шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх," гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Эрх бүхий байгууллагаас баталсан хууль, дүрэм, журмыг мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сум дундын ойн анги	2	420.0	0	0	1	420.0	0	0	1	0
Дүн		2	420.0	0	0	1	420.0	0	0	1	0